



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 13/52

Улаан-Уул

Г Хамтарсан багийг шинэчлэн
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3,35 дугаар зүйлийн 35.1.17, 48 дугаар зүйлийн 48.1, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 13 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь;

1. Хамтарсан багийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж хавсралтаар баталсугай.


2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажлыг зохион байгуулахдаа “Хамтарсан багийн ажиллах журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд танилцуулахыг хамтарсан багийн ахлагч, сумын Засаг дарга (Т.Эрдэнэбат)-д даалгасугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 13 дугаартай тогтоолыг хүчингүй болгосугай.



Ёсчилсон 2022 оны 12 сарын 19 ны өдөр

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит
13 дугаар хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 19-ний
өдрийн 13/52 дугаар тогтоолын хавсралт



ХАМТАРСАН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Хамтарсан багийн ахлагч: Сумын Засаг дарга

Нарийн бичгийн дарга: Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Гишүүдэд: Тамгын газрын дарга

Цэцэрлэгийн эрхлэгч

Эрүүл мэндийн төвийн дарга

Сургуулийн нийгмийн ажилтан

Хөдөлмөр, халамжийн мэргэжилтэн

Эрүүл мэндийн төвийн нийгмийн ажилтан

Багийн Засаг дарга нар

Цагдаагийн алба хаагчид (хэсгийн төлөөлөгч, хэв журмын цагдаа, олон
нийтийн цагдаа)

Төрийн бус байгууллагын төлөөлөл (Ахмадын холбоо, эмэгтэйчүүдийн
холбоо, залуучуудын холбооны удирдлага)

Байрын багш нар

Насан туршийн боловсролын багш менежер

Сургуулийн сэтгэл зүйч

Хүүхдийн элч

----oO----